

ОНЦГОЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
хошууч Н.Нямхорлоо

МОНГОЛ ОРОНД ТОХИОЛДСОН БАЙГАЛИЙН АЮУЛТ ҮНЭЭГДЭЛ ТҮНЭЭНИЙ ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Дэлхийн дулааралт нь эрс тэс уур амьсгалтай манай орны байгаль, цаг агаар, уур амьсгалд хлэгтэй нөлөөлснээр байгалийн аюулт үнээгдэл түнэний дотор агаар мандлын гаралтай аюулын давтамжид ихээхэн нөлөөлж байна. Мөн сүүлийн 40 жилд Монгол Улсын хэмжээнд жилдээ 25-30 удаа агаар мандалын гаралтай аюулт үнээгдэл тохиолдож, 3/1 орчим нь байгалийн гамшигийн хэмжээнд хлрч, жил тутамд 5-7 тэрбум түгрлийн хохирол учруулж байсан бол 90-ээд оны дунд үеэс хойш ган, зудыг тооцохгүйгээр ус, цаг агаарын түр зуурын гамшигт үнээгдлийн улмаас учирдаг хохирлын хэмжээ жил бүр 10-12 тэрбум түгрлгт хлрэх болсон байна¹.

Дэлхийд хлн амыг олноор нэрвэгдэж, тухайн орны эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг 30 гаруй түрлийн байгалийн гамшиг тохиолдож байна². Монголд сүүлийн 15 жилд тохиолдсон байгалийн аюулт үнээгдлийг цаг агаарын, биологийн, геологийн гаралтай гэсэн 3 түрлээр хуваан авч үзвэл нийт тохиолдлын 61% цаг агаарын, 32% биологийн, 7% геологийн гаралтай аюулууд тус тус эзэлж байна³.

Байгалийн аюулт үнээгдлийн ихэнх хувийг цаг агаарын гаралтай аюулт үнээгдэл эзэлж байгаа нь дэлхийн дулаарал, экологийн доройтолтой холбоотойгоор улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Аливаа гамшиг, аюулт үнээгдлүүд нь хлний амь нас, амьжиргааны хэрэгслийг сүйтгэн, олон хлнийг ядууралд хлргэж, зүтгэл чармайлтаар буй болсон хлгжлийн ололтыг сүйтгэдэг⁴. Аюулт үнээгдлийн түлв байдал, түнний тархацыг тодорхойлох нь гамшигийн эрсдэлийг бууруулах асуудлыг улс орон, бүс нутаг цаашлаад аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийг хлгжлэх үндсэн чиглэл, бодлого, хл түлбэрүүдэд тусгах ажлын үндэс суурь болох учиртай.

Британийн “Oxfam” хэмээх түрийн бус байгууллагаас 2008 онд гаргасан илтгэлд гамшигийн тоо сүүлийн 20 жилд дүрв дахин ихэссэн хэмээн бичжээ. Оксфамын судлаачид байгалийн гамшигт үнээгдэл 1980-аад оны эхэн үед жилд 120-оор нэмэгддэг байснаа 2008 он гэхэд жил тутам ойролцоогоор 500-аар нэмэгдэж байгааг тэмдэглэсэн. Энэ үсүлтийг авч үзвэл геологийн гаралтай аюул (газар

¹ Цаг агаарын гамшигт үнээгдэл 2008.5.26-27-нд Зүүн аймгуудад тохиолдсон цаг агаарын гамшигт үнээгдлийн тухайлсан судалгааны тайлан. НН БХХ-ийн МОН /08/ 305 түсүл, 2008.

² Annual Disaster Statistical Review, The numbers and trends 2007, Center for Research on the Epidemiology of Disasters (CRED), www.emdat.be

³ Д.Сэржмядаг. Байгалийн гамшигийн менежмент түннийг боловсронгуй болгох нь.

"Гамшигийн менежмент" эмхэтгэл 2008.

⁴ Ярианаас үйл ажиллагаа: Хөдөөгийн үйл ажиллагааны хлрээг хэрэгжүлэх удирдамж 2009.

хөдлөлт, галт уул зэрэг)-ын тоо харьцангуй тогтмол хэвээр бол цаг агаарын аюулт үзэгдэл (пер, хөчтэй салхи зэрэг)-ийн тоо мэдэгдэхгүй нэмэгдсэн ажээ¹.

Энэхүү үзэлтийг хоёр зүйлтэй холбон тайлбарлаж болох юм. Нэгт, уур амьсгалын үрчлөлт ба байгаль орчны доройтлоос шалтгаалж аюулт үзэгдлийн тоо нэмэгдэж байна. Харин гамшгийн үзэлтийг тайлбарлах дараагийн зүйл бол эмзэг байдалтай газар нутагт суурших хүн амын тоо нэмэгдсэн явдал бөгөөд хүмүүс ихэвчлэн хот суурин газарт сууршин амьдрах болсон нь тэдгээрийн бөх төрлийн гамшигт өртөх эмзэг байдлыг нь нэмэгдүүлж байна. Өөрөөр хэлбэл, хүн ам сийрэг суурьшсан газарт аюулд цохно тооны хүн өртөж, багахан хохирол амсдаг бол хүн ам шигүү суурьшсан хот суурин газарт бол энэ нь их хэмжээний хохирол учирч гамшиг болох магадлалтай юм.

Монгол орны байгаль, цаг уур, эдийн засаг, нийгмийн онцлог нь цаг агаарын гаралтай аюулт үзэгдэлд өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байдаг. Хангай говь хосолсон өргөн уудам нутаг, бэлчээрийн мал аж ахуй, усалгаагүй газар тариалан эрхэлдэг манай орны хувьд өвлөх цас, зуд, цочир хүйтрэлт, хавар салхи шуурга, ой хээрийн төймэр, зун ган, пер, аадар, мөндөр, намар хүйтэн бороо, нойтон цас зэрэг агаар мандлын гаралтай аюулууд жилийн дөрвөн улиралд ээлжлэн давтагдаж байдаг.

Сүүлийн 100 жилд дэлхийн агаарын температур 0.74°C-ээр дулаарсан бол Монгол орны агаарын дундаж температур сүүлийн 69 жилд 2.1°C-ээр дулаарсан бөгөөд дэлхийн дунджаас даруй 3 дахин их байна.

Монгол оронд газар орчмын агаарын температур уулархаг нутгаараа илүү эрчимтэй (2.0-3.7°C), говь, тал хээрийн бөсөндээ арай бага хэмжээгээр (0.7-2°C) дулаарсан бол жилийн нийлбэр хур тунадас төв болон говийн бөсөөр 8.7-12.5 хувиар буурсан, зөвхөн болон баруун талын нутгаар 3.5-9.3 хувиар өссөн байна.

Цаашид дулаарал нэмэгдэх бөгөөд 2100 он гэхэд жилд дунджаар -12...-3 хэм байдаг Алтай, хангай, Хөвсгөлийн уулархаг орон -3...+3 хэм, -6...0 хэмтэй байсан Их нууруудын хотгор, Орхон Сэлэнгийн сав газар, Халх гол +3...+6 хэм, говь хээрийн бөс +6 хэмээс дулаан болох ажээ.

Дэлхийн дулаарлаас үүдэлтэй уур амьсгалын үрчлөлт нь дараах сөрөг нөлөөллийг бий болгож болзошгүй юм. Үүнд:

- хур борооны хэмжээ алгуур буурах, агаарын температур нэмэгдэх
- зуны хур борооны хэлбэр (аадар, зөвхөн бороо г.м) алгуур үрчлөгдөх
- зуны борооны улирал буюу 7-р сарын сүүл ба 8-р сарын эхээр хэт халах
- хүрс хуурайших, усны ууршил нэмэгдэх
- мөндөр уулын бөсөнд мөнх цэвдэг, мөнх цас хайлах
- гэнэтийн аюулын давтагдал, хохирол нэмэгдэх
- зарим амьд организм хэт олшрох
- хортон шавьж ихсэх
- халдварт өвчин дэгдэх
- ой, хээрийн төймэр нэмэгдэх
- зуд, ган, цөлжилт нэмэгдэх


¹ Gutierrez, Introduction to Intonation disaster management p.26, 2008.

Ийнхүү уур амьсгалын өөрчлөлтөөс үлдсэн байгалийн аюулт нэгдлийн давтамж, эрч хич нэмэгдсэнээр нийгмийн амьдрал, цаашлаад улс орны эдийн засаг, хөний хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Учир нь эдийн засаг, цаашлаад хөний хөгжлийн асуудал нь уур амьсгалын өөрчлөлт, хэрэглэн буй орчноос хамааралтай хэвээр байсаар байна. Тухайлбал, Монгол Улсын ДНБ-ны 20% ХАА-гаас, нийт 14 аймгийн (Орхон, Дархан, Говь-сүмбэрээс бусад) ДНБ-ний дийлэнх хувийг ХАА-н салбараас бүрдүүлж байгаа нь эдийн засаг-нийгмийн байдал байгаль орчноос хэр хамааралтай байгааг харуулж байна.

Байгалийн аюулт нэгдлийн нөхцөл байдал нь гамшгийн менежментийг сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд нэн чухал ач холбогдол бүлх ёстойг харуулж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг авч үзэхийн өмнө эрсдэлийг бүрдүүлэгч хичин зүйлүүдийн талаар тодруулъя.

“Гамшиг” гэж аюулт нэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хөний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хэрэглэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг¹; “гамшгийн эмзэг байдал” гэж гамшгийн болзошгүй аюулд хичн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хэрэглэн байгаа орчин бүртгдлх зэргийг²; “гамшгийн эрсдэл” гэж гамшгийн улмаас хичн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хэрэглэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлалыг³ хэлнэ.

Гамшгийн эрсдэл нь аюул, эмзэг байдал гэсэн 2 хичин зүйлээр тодорхойлогдоно.



“Эрсдэлийг бууруулах” гэж гамшиг өөсгөх онц аюултай объектууд, экологи, байгалийн аюултай нэгдлүүдийг ажиглах, хэрэглэн байгаа орчны тлөвт мониторинг хийх, хууль эрх зүй, зохион байгуулалт, эдийн засаг, инженер техник, экологийн хамгаалалт, эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээнүүдийг тусгасан цогц бодлого явуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээг⁴ хэлнэ.

Манай улс гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, чадавхийг бэхжүүлэх өндөсний хөтөлбөр 2011-2020 он зэрэг баримт бичгүүдэд Хиогогийн үйл ажиллагааны хэрэгжүүлэх асуудлыг тодорхойлж өгсөн. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын өндсөн чиглэлд гамшгийн эрсдэлийг бууруулах талаар “Байгалийн болон хөний хичин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн өнэлгээ хийх” гэж тусгасан байна. Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх өндөсний хөтөлбөрийн хөрөөнд хэрэгжүүлэх арга хэмжээнд:

¹ Монгол Улсын Гамшгаас хамгаалах хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2. дах заалт.

² Мөн хуулийн 4.1.6.

³ Мөн хуулийн 4.1.5.

⁴ Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, MNS 6010:2009 стандарт

- Эрсдэлийн нэлгээний аргачлалыг учирч болзошгүй байгалийн болон хэргийн хэргийн зүйл, техникийн гаралтай гамшгийн аюул, тэв, орон нутгийн газар зүйн байршил, эдийн засаг, нийгмийн онцлог, хөгжлийн бодлого, олон улсын жишиг нэлгээний аргачлалд тулгуурлан боловсронгуй болгох;

- Болзошгүй гамшгийн эрсдэл, түүний нөлөөллийн талаарх статистикийн мэдээ, огцролтийг цуглуулах арга хэмжээг стандартчилах, гамшгийн мэдээллийн сангийн үйлчилгээг боловсронгуй болгох;

-Бүс нутгийн болон хил дамнасан болзошгүй гамшгийн эрсдэлийг үнэлэх;

-Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх;

-Эрсдэлийн зураглал, мэдээллийг боловсруулах, дамжуулах техникийн хэрэгсэл чадлыг нэмэгдүүлэх гэсэн асуудлыг тусгасан байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад эрсдэлийг тодорхойлогч хэрэгсэл зүйлс болох аюул, эмзэг байдлыг бууруулах арга хэмжээнээс гадна түүнийг хэрэгжүүлэх байгууллагын чадавхийг сайжруулах үйл ажиллагаатай холбоотой. Онцгой байдлын албаны үйл ажиллагаа бүхэлдээ гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэдэг хэдий ч гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нь олон талт нарийн төвөгтэй асуудал тул Онцгой байдлын алба түүнийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлагдана. Гамшгийн эрсдэлийг бууруулж чадсанаар улс орны тогтвортой хөгжих нөхцөл боломж бүрдэж ялангуяа эдийн засгийн хөгжил болон хэргийн хөгжлийн асуудал нь уур амьсгалын өөрчлөлт, хэрэглэн буй орчноос ихээхэн хамааралтай улсын хувьд байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нэн тэргүүнд тавигдах шаардлагатай.

Дүгнэлт

Манай оронд тохиолдож буй байгалийн аюулт үзэгдлийн давтамж дэлхий дахиныг хамарсан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй цаашид нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд улс орны эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл ч түүнийг дагаад өсөх магадлалтай юм.Иймд байгалийн аюулт үзэгдэлд тандан судалгаа, мониторинг хийж аюулыг эрт зарлан мэдээлэх, нийгэм, эдийн засгийг хөгжүүлж, аюулд өртөх эмзэг байдлыг багасгах зэрэг багц арга хэмжээгээр дамжуулж гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг бүх талын оролцоо, төвшлэл хамтын ажиллагаанд тулгуурлан хийх нь ихээхэн өрсөлттэй болох нь дэлхийн улс орнуудын туршлагаар нэгэнт батлагдаад байгаа учир гамшгийн эрсдэлийг бууруулахын ач тусыг хүлээн зөвшөөрч бүх төвшинд энэ асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй байна.

ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч, ахмад
Ц.Эрдэнэбилэг

ГАМШИГ ОСЛЫН ҮЕИЙН УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ

Орчин үед дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын дулаарал болон хэргийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг давамгайлах болж гамшгийн улмаас улс